



Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баруун-Урт сум 2025 он



Дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Аудитор Г.Оюунболд

Утас: 70512127 Цахим хаяг: Oyunboldg@audit.gov.mn

Аудитор О.Барчидгүнсэн

Утас: 70512127 Цахим хаяг: Barchidgun-
seno@audit.gov.mn

Агуулга

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

4

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ	4
БҮЛЭГ 1. Орон нутгийн орлогын гүйцэтгэл 9,326.1 сая төгрөгөөр тасарсан нь орлогын бааз суурийг бодитой үнэлээгүй, татвар ногдуулалт, бүрдүүлэлт, хяналт сул, газрын дуудлага худалдаа зохион байгуулагдаагүй, зудын нөлөөлөл бий болсон зэрэгтэй холбоотой бөгөөд энэ нь төсвийн сахилга бат, орлогын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлсөн байна.	6
1.1 Аймгийн ИТХ-аар орон нутгийн төсөвт тодотгол хийж санхүүгийн дэмжлэгийг 2,102.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ.	6
1.2 Орон нутгийн төсвийн орлогын хүрээнд газрын дуудлага худалдаа зохион байгуулагдаагүйгээс үүдэн 2,027.8 сая төгрөгийн орлого тасарсан нь төлөвлөсөн орлогын гүйцэтгэлд мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлсэн байна.	7
БҮЛЭГ 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хүрээнд иргэдийн саналаар эрэмбэлэгдсэн төсөл, арга хэмжээнд тайлант хугацааны дундуур өөрчлөлт оруулсан нь төслийн хэрэгжилтийн төлөвлөлт, хэрэгжилтийн дараалалд нөлөөлж, иргэдийн оролцоо, итгэлцлийг бууруулах, мөн тухайн жилийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй нөхцөл байдал үүсгэсэн байна.	9
2.1 Аймгийн ИТХ-ын 2024 оны 9 сарын 19-ний өдрийн 07 дугаар тогтоолоор ОНХСангийн зарим ТАХ-г өөрчлөн баталсан байна.	9
2.2 Орон нутгийн төсвийн зарлагын бүтцэд урсгал зардал 71 хувь, хөрөнгийн зардал 27 хувь, цэвэр зээл 2 хувийг тус тус эзэлж байгаа нь төсвийн ихэнх хэсэг нь урсгал зардалд чиглэж, эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтын чиглэлийн санхүүжилт харьцангуй бага байгааг илтгэж байгаа тул хөгжлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгийн зардлын эзлэх хувийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.	10
БҮЛЭГ 3. Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 413 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 46 хувьтай байгаа нь төсвийн орлогын тасралт, худалдан авах ажиллагааны хоцролт, зохион байгуулалт хангалтгүй зэргээс шалтгаалж, хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулсан байна.	11
3.2 Их засварын чиглэлээр нийт 14 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс он дамжин хэрэгжсэн арга хэмжээ бүрэн дууссан бөгөөд шинээр эхлүүлсэн арга хэмжээний гүйцэтгэл 80 хувийн биелэлттэй байна.	13
3.3 Орон нутгийн хөрөнгө оруулалт 80.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд 3 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгоогүй байна.	14
3.4 Авто замын сангаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ 80 хувийн гүйцэтгэлтэй боловч авто замын нөхөөсний ажлыг чанаргүй гүйцэтгэсэн байна.	15
БҮЛЭГ 4. Орон нутгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг төсвийн төсөлтэй уялдуулсан байна.	16
4.1 Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан шалгуурт нийцүүлэн тайлагнасан байна.	16
4.2 Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд батлагдсан зарим арга хэмжээний санхүүжүүлэх эх үүсвэрийг төсвийн төсөлд бүрэн тусгаагүйгээс хэрэгжээгүй байна.	17
БҮЛЭГ 5. Нэмэлт төсвийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн, зарцуулжээ.	18
БҮЛЭГ 6. Санхүү, төсвийн үйл ажиллагаатай холбоотой ил тод мэдээлбэл зохих мэдээллийг ШДНЦХ-т байршуулаагүй, хугацаа хоцроож мэдээлсэн байна.	19
ДҮГНЭЛТ	21
ЗӨВЛӨМЖ:	21
Холбогдох байгууллагын санал:	Error! Bookmark not defined.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
МНС	Монгол улсын стандарт

ДҮРСЛЭЛИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №1	Аймгийн ИТХ-аар баталсан 2023 оны төсвийг санхүүжүүлэх эх үүсвэр
Хүснэгт №2	Төсвийн орлогын гүйцэтгэл
Хүснэгт №3	Татварын орлогын гүйцэтгэл
Хүснэгт №4	Татварын бус орлогын гүйцэтгэл
Хүснэгт № 5	Төсвийн зарлагын гүйцэтгэл
Хүснэгт № 6	ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээний гүйцэтгэл
Хүснэгт №7	Их засварын зардлаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гүйцэтгэл
Хүснэгт № 8	Удирдлага болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлаар гүйцэтгэх төсөл арга хэмжээний гүйцэтгэл
Хүснэгт №9	Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэл
Хүснэгт № 10	Төсвийн гүйцэтгэл /хөтөлбөрөөр/
Хүснэгт № 11	Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлт
Хүснэгт № 12	Орон нутгийн нэгдсэн төсвийн нэмэлт төсвийн гүйцэтгэл
Хүснэгт № 13	ШДТ хуулийн зөрчлийн нэгтгэл

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Аудит үндэслэл, эрх

хийх бүрэн

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/108 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдэв, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэв.

Аудитын зорилт

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан аймгийн ИТХ болон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахад дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

1. Орон нутгийн 2024 оны төсвийн орлогыг бодитой төлөвлөж, төвлөрүүлсэн эсэх
2. Орон нутгийн 2024 оны төсвийн зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулсан эсэх
3. Тухайн жилд хэрэгжих хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл
4. Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн эсэх
5. Нэмэлт төсвийн гүйцэтгэл
6. Шилэн дансны тухай, ТХТ хуулийн хэрэгжилт

Аудитын хүрээ хамарсан

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, Сангийн яамнаас Сүхбаатар аймгийн 2024 оны төсвийн суурь, орлого зарлагыг хянаж ирүүлсэн тооцоо болон бусад материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт, шалгалтын стандарт, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, тайлан баримт материалд тулгуурлан харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор Г.Оюунболд, О.Барчидгүнсэн нар гүйцэтгэв.

БҮЛЭГ 1. Орон нутгийн орлогын гүйцэтгэл 9,326.1 сая төгрөгөөр тасарсан нь орлогын бааз суурийг бодитой үнэлээгүй, татвар ногдуулалт, бүрдүүлэлт, хяналт сул, газрын дуудлага худалдаа зохион байгуулагдаагүй, зудын нөлөөлөл бий болсон зэрэгтэй холбоотой бөгөөд энэ нь төсвийн сахилга бат, орлогын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлсөн байна.

1.1 Аймгийн ИТХ-аар орон нутгийн төсөвт тодотгол хийж санхүүгийн дэмжлэгийг 2,102.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ.

1.1.1 Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 06 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын тогтоолын дагуу 2024 оны орон нутгийн төсвийн орлого, зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийт 93,740.5 сая төгрөгөөр төлөвлөж, баталсан.

Төсвийн орлогын бүтэц:

Орлогын төрөл	Дүн (сая төгрөг)	Нийт эх үүсвэрт эзлэх хувь
Татварын орлого	42,477.8	45.2%
Татварын бус орлого	8,505.2	9.1%
Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого	4,304.9	4.6%
Тусламж, санхүүгийн дэмжлэг	32,133.3	34.2%
Урьд оны төсвийн үлдэгдэл	6,319.3	6.7%
Нийт	93,740.5	100%

1.1.2 Сүхбаатар аймгийн 2024 оны төсвийг Төсвийн тухай хууль, "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах" журам, аймгийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1, 8.5.2-т заасан цаглабарын дагуу тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлсэн байна.

1.1.3 Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар Сүхбаатар аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 11,815.3 сая, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 17,474.9 сая төгрөгөөр тус тус баталсан байна. Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 2,102.3 сая, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 740.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталжээ.

1.1.4 Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн хүрээнд аймаг, сумдын ИТХ-ын "Төсвийн тодотгол батлах тухай" тогтоолд орон нутгийн төсвийн зарлагыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 10,091.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 103,951.5 сая төгрөгөөр баталжээ.

1.1.5 Орон нутгийн төсөвт аймаг 3 удаа, сумд 1 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулж тодотгол хийжээ. Үүнээс аймгийн ИТХ-аар баталсан тодотголыг авч үзвэл:

Хүснэгт №1 Аймгийн ИТХ-аар баталсан 2024 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэр /сая төгрөг/

№	Орлогын нэр, төрөл	Анх баталсан		Тодотгол	
		2023.12.04	2023.12.28	2024.04.29	2024.09.19
А	Б	1	2	3	4
1	Татварын орлого	24,657.7	24,657.7	24,657.7	22,755.4
2	Татварын бус орлого	6,160.0	6,160.0	6,160.0	6,160.0
3	Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого	65.0	65.0	65.0	65.0
4	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	11,815.3	11,815.3	11,815.3	13,917.6
5	ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг	17,474.9	17,474.9	17,474.9	18,215.7
6	Урьд оны үлдэгдлээс	1,889.5	7,126.1	7,126.1	7,126.1
Аймгийн нийт орлого /сумдаас бусад/		62,713.6	67,950.3	67,950.3	68,891.1

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн ИТХ-ын төсөв батлах, тодотгох тухай тогтоол

1.1.6 Тодотгол хийсэн нөхцөл байдлыг авч үзвэл:

• **Аймгийн 2023.12.04-2023.12.28-ний өдрийн ИТХ-аар:**

Тодотголоор аймгийн 2024 оны төсвийн зарлагын санхүүжүүлэх эх үүсвэрийг 5,236.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн аймгийн нийт орлогыг 67,950.3 сая төгрөгөөр баталжээ.

1.1.7 Аймгийн ИТХ-аас 2024 оны 09 дүгээр сарын 19 -ны өдөр тодотгол хийсэн байна. Тодотгол хийсэн нөхцөл байдлыг авч үзвэл:

• **Аймгийн 2024.09.19-ны өдрийн ИТХ-аар:**

Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотой орон нутгийн төсөвт тодотгол хийгджээ. Төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдэж, дээд шатны төсөвт тодотгол хийгдсэнээс орон нутгийн төсөвт нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд уг тодотголоор санхүүгийн дэмжлэгийг 2,102.3 сая, ОНХНС-аас хуваарилагдан ирэх орлогын шилжүүлгийг 740.8 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлжээ. Мөн газрын дуудлага худалдааны орлогын төлөвлөгөөг 1,902.3 сая төгрөгөөр бууруулж төсвийн зарлагын эх үүсвэрийг санхүүжүүлэхээр тус тус тодотгосон байна.

1.2 Орон нутгийн төсвийн орлогын хүрээнд газрын дуудлага худалдаа зохион байгуулагдаагүйгээс үүдэн 2,027.8 сая төгрөгийн орлого тасарсан нь төлөвлөсөн орлогын гүйцэтгэлд мэдэгдэхүйц сөрөг нөлөө үзүүлсэн байна.

1.2.1 Сүхбаатар аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийн 07 тоот тогтоол болон сумдын ИТХ-ын “Төсвийн тодотгол батлах тухай” тогтоолд 2024 оны төсвийн нийт орлого, тусламжийн дүнг 83,236.3 сая төгрөгөөр төлөвлөснөөс 73,910.2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №2 Төсвийн орлогын гүйцэтгэл /сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	83,236.3	73,910.2	(9,326.1)
Татварын орлого	42,477.8	37,561.0	(4,916.8)
Татварын бус орлого	8,505.2	4,814.2	(3,691.0)
Хөрөнгө худалдсаны орлого	120.0	102.1	(17.9)
Тусламж, санхүүжилтийн орлого	32,133.3	31,432.9	(700.4)

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

1.2.2 Тайлант оны татварын орлогын гүйцэтгэл 37,561.2 сая төгрөг буюу төлөвлөснөөс 4,916.6 сая төгрөгөөр тасарсан байна.

Хүснэгт №3 Татварын орлогын гүйцэтгэл /сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэл
ТАТВАРЫН ОРЛОГО	42,477.8	37,561.0	4,916.8	88
Газрын дуудлага худалдаа	4,175.5	2,137.7	2,037.8	51
Шууд бус орлого	405.9	1,308.3	(902.4)	322
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	19.3	10.1	9.2	52
Малд ногдуулах албан татвар	1,220.2	793.8	426.4	65
Байгалын ургамлын нөөц ашигласны төлбөр	1.0	137.5	(136.5)	-
Хог хаягдал үйлчилгээний хураамж	229.6	173.7	55.9	76
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	447.3	704.6	(257.3)	158
ААН-ын орлогын албан татвар	17,000.0	9,584.2	7,415.8	56
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(761.1)	(761.1)	-	100
Үйл ажиллагааны орлого	1,355.1	2,141.7	(786.6)	158
Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашиглахад олгох эрхийн зөвшөөрлийн хураамж		20.0		
Бусад татвар	1.0			

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Бууны албан татвар	30.1	40.0	(9.9)	133
Хөрөнгийн орлого	952.5	1,365.9	(413.4)	143
Улсын тэмдэгтийн хураамж	101.1	445.9	(344.8)	441
Газрын төлбөр	447.5	520.0	(72.5)	116
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн	690.0	862.7	(172.7)	125
Үл хөдлөх хөрөнгийн татвар	729.9	783.8	(53.9)	107
Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	14,173.2	15,727.2	(1,554.0)	111
Хөрөнгө борлуулсны орлого	344.2	448.8	(104.6)	130
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	915.5	1,116.2	(200.7)	122

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

1.2.3 Татварын орлогын гүйцэтгэл нийт дүнгээр 88 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд дараах нэр төрлийн орлогууд тасарсан байна. Үүнд:

- *Газрын дуудлага худалдааны орлого 2,037.8 сая төгрөгөөр тасарсан нь газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газрын дуудлага худалдаа зохион байгуулагдаагүй.*
- *Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 9.2 сая төгрөгөөр тасрахад Сүхбаатар, Эрдэнэцагаан сумдын мэргэжилтэн ногдуулалт, хяналтыг хэрэгжүүлээгүй.*
- *Байгалийн гамшигийн улмаас 2024 онд Асгат, Баяндэлгэр, Дарьганга, Мөнххаан, Онгон, Сүхбаатар, Түвшинширээ, Түмэнцогт, Уулбаян, Халзан, Баруун-Урт сумдын ИТХ-аар МТТАТ-ын хувь хэмжээг 0 төгрөг байхаар тогтоосон, малчид малгүй болсон гэх шалтгаанаар 2023 онд энэ төрлийн татварын өр их хэмжээгээр үүссэн нь малд ногдуулах албан татвар 426.4 сая төгрөгөөр буурахад нөлөөлсөн байна.*
- *Хог хаягдлын хураамж 55.9 сая төгрөгөөр тасарсан нь хог хаягдлын хураамжийг төсөвт төвлөрүүлэх ажлыг сумдын ЗДТГ хангалтгүй зохион байгуулдаг нь голлон нөлөөлж байна. Иймд Хог хаягдлын тухай хуулийн 29-р зүйлийн 29.2-д "Сум, дүүргийн Засаг дарга, орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагч хог хаягдлын хураамжийг хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна." оруулж 2025 оны 6 сарын 1-ээс хэрэгжүүлэхээр нэмэлт өөрчлөлт оруулсан байна.*
- *Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 7,415.8 сая төгрөгөөр тасарсан нь Сангийн яам орлогын татварын 40 хувийн хуваарилалтыг 8,500.0 сая төгрөгөөр хянасан боловч аймгийн ИТХ-аас 17,000.0 сая төгрөгөөр баталсан байна.*

1.2.4 Төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр тасарч, газрын дуудлага худалдаа зохион байгуулагдаагүй, татвар ногдуулалт, хяналт хангалтгүй хэрэгжсэн, зудын улмаас малын татвар буурсан, хог хаягдлын хураамжийн төвлөрүүлэлт хангалтгүй зохион байгуулагдсан, орлогын татварын хуваарилалт бодит бус батлагдсан зэрэг шалтгаанаар тасарсан нь орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлсөн байна.

1.2.5 Аймгийн 2024 оны татварын орлого нийт дүнгээр 22 хувиар тасарсан боловч зарим

- *Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ нэмэгдсэн, газрын төлбөрийн нэхэмжлэх нь газрын албаны мэдээллийн сангаас татварын мэдээллийн сан руу шууд татагддаг. Сумдын газрын даамал гэрээний сунгалт хийх, шинэчлэх ажлыг хангалтгүй хийдгээс бага төлөвлөгдсөн.*
- *Ан амьтны нөөц ашигласны төлбөр хэтэрсэн нь жил бүрийн төсөв хянахад байгаль орчны яам шонхор шувуу барих тоо толгойг төлөвлөөгүй байдаг тул төлөвлөлт хийхэд хүндрэлтэй байдаг.*
- *Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслэлийн албан татвар давахад 2024 онд уул уурхайн тээврийн компаниудын тээврийн хэрэгсэлд аймгийн дугаар олгосноор 199.5 сая төгрөгөөр нэмэгдсэн.*
- *Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татвар өсөхөд төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэн.*
- *Хөрөнгө борлуулсны орлогын татвар өсөхөд ипотекийн зээлийн олголт нэмэгдсэн, Соёмбо, Тэмүүлэл, Хос өргөө, Шинэ саруул зэрэг хотхонууд шинээр баригдсан нь орлогын давалтад нөлөөлсөн байна.*

орлого төлөвлөснөөс 3,158.1 сая төгрөгөөр давж биелсэн байна. *Тухайлбал:*

Гэхдээ Газрын төлбөр болон ан амьтны төлбөрийн орлого нь салбар хоорондын уялдаа, мэдээлэл солилцооны тогтолцоо хангалтгүйгээс төлөвлөлт үндэслэл багатай хийгдэж, зөрүү ихтэй тооцогдох нөхцөл үүсгэдэг хэвээр байна. Мөн Зарим орлого хэтэрч, зарим нь тасарч, төсвийн орлогын бүтэц хэлбэлзэлтэй болсноор зарлагын төлөвлөлтөд хүндрэл үүсгэж байна.

1.2.6 Татварын бус орлогыг 12,810.1 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 8,657.5 сая төгрөгийн орлого төвлөрч 67 хувийн биелэлттэй гарчээ.

Хүснэгт №4 Татварын бус орлогын гүйцэтгэл /сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэл
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,810.1	8,657.5	(4,152.6)	67
Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого	4,304.9	3,843.3	(461.6)	89
Хүү, торгуулийн орлого	3,123.0	1,755.3	(1,367.7)	56
Бусад орлого	5,382.2	3,059.0	(2,323.2)	56

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

1.2.7 Татварын бус орлого тасрахад дараах хүчин зүйл нөлөөлжээ. Үүнд

- Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого тасрахад хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн болон зээлийн хүүгийн эргэн төлөлт 214.7 сая төгрөгөөр, Сүхбаатар сумын боловсрол, эрүүл мэндийн санд төвлөрдөг гадаад ажилчдын ажлын байрны төлбөр 246.9 сая төгрөг төвлөрөөгүй нь нөлөөлсөн.
- Хүү, торгуулийн орлого сумдын хэмжээнд тасраагүй боловч аймгийн орлогыг 2,240.0 сая төгрөгөөр төлөвлөж 912.0 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 1,328.0 сая төгрөгөөр тасарсан байна. Хүү, торгуулийн орлогыг төлөвлөхдөө өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлаагүй хэт өндөр төлөвлөсөн нь орлого тасрахад нөлөөлсөн байна.
- Бусад орлого 2,323.2 сая төгрөгөөр тасарсан нь уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулсан боловч гэрээний үүргээ биелүүлээгүйгээс тасарсан байна. Тухайлбал: Эрдэнэцагаан сумын төсөвт 578.2 сая төгрөг төвлөрүүлэхээс 446.1 сая төгрөг төвлөрүүлээгүй байна.

1.2.8 Татварын болон татварын бус орлого төлөвлөгөөнөөс тасарсан нь орлогын бааз суурийг бодитой үнэлэхгүйгээр төсөв боловсруулсан, төрийн захиргааны байгууллагуудын уялдаа холбоо, хяналт-шалгагдах ажиллагаа сул байгаатай холбоотой бөгөөд энэ нь төсвийн орлогын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж, зарим төрийн үйлчилгээний санхүүжилтийг хязгаарлах, ирэх онуудын төсвийн төлөвлөлт, дотоод хяналт, хариуцлагын тогтолцоог алдагдуулах эрсдэлийг бий болгож байна.

БҮЛЭГ 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хүрээнд иргэдийн саналаар эрэмбэлэгдсэн төсөл, арга хэмжээнд тайлант хугацааны дундуур өөрчлөлт оруулсан нь төслийн хэрэгжилтийн төлөвлөлт, хэрэгжилтийн дараалалд нөлөөлж, иргэдийн оролцоо, итгэлцлийг бууруулах, мөн тухайн жилийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй нөхцөл байдал үүсгэсэн байна.

2.1 Аймгийн ИТХ-ын 2024 оны 9 сарын 19-ний өдрийн 07 дугаар тогтоолоор ОНХСангийн зарим ТАХ-г өөрчлөн баталсан байна.

2.1.1 Аймгийн ИТХ-ын 2024 оны 07 сарын 9-ний өдрийн 04 тоот тогтоолоор Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6 “а” дахь заалтыг үндэслэн дараах арга хэмжээнүүдэд өөрчлөлт хийсэн байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих “Үйлдвэрлэлийн 2-р бүсийн дэд бүтцийн зураг төсөл, Баруун-Урт сум”, “Бохирын шугам сүлжээ барих ажилд аймгийн оролцоо, Уулбаян, Түвшинширээ сум” төсөл, арга хэмжээг хасаж “Баруун-Урт хотын ерөнхий төлөвлөгөөний тодотгол”, “Түмэнцогт сумын уурын зуухны тогооны шинэчлэл”, “Чип төслийн цахилгаан хангамжийн дэд станц худалдан авах”, “Амгалан гэр хорооллын

шугам сүлжээний ажлын зураг төсөл” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр тодотгосон байна.

- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хэрэгжүүлэх “Цаг хүндэрсэн үед 5 сумын нутаг дэвсгэрт тархсан аргал, халиун бугад 5 тн хужир, 500 боодол өвс бэлтгэн биотехнологийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх” арга хэмжээний санхүүжилтээс 1.0 сая төгрөг, “8 байршилд мэдээллийн самбар байршуулах” арга хэмжээний 18.0 сая төгрөгийн санхүүжилтийг хасаж “Баруун-Урт суманд 5 га хамгаалалтын зурвас байгуулсан модны усалгааны зардал” арга хэмжээнд нэмж өөрчлөхөөр зохицуулалт хийсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх иргэдийн саналаар эрэмбэлэгдсэн төсөл, арга хэмжээг тайлант хугацааны дундуур өөрчлөн, шинэ төсөл, арга хэмжээг тусгаж, эхний байдлаар төлөвлөгдсөн зарим төслийг хассан нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээний журам”-ын 7.6, 7.7 дахь заалтыг зөрчсөн бөгөөд энэ нь иргэдийн оролцоонд үндэслэн хэрэгжүүлэх ёстой төсвийн зарцуулалтын ил тод, хариуцлагатай байдлыг алдагдуулах, иргэдийн оролцоог бууруулах, тухайн жилийн батлагдсан төлөвлөгөө, тайлангийн хооронд зөрүү үүсгэх, сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бий болгож байна.

2.1.2 Мөн аймгийн ИТХ-ын 2024 оны 9 сарын 19 өдрийн 07 тоот тогтоолоор ИТХ-ын зардал 100.0 сая, орон нутгийн төсвийн нөөц хөрөнгийг 200.0 сая, гэрээгээр гүйцэтгүүлэх арга хэмжээг ОНӨҮГазар 150.0 сая, усан хангамж, ус цэвэршүүлэх байгууламж, бохир усны цэвэрлэх байгууламжийн татаас 260.0 сая нийт 710.0 сая төгрөгийн урсгал зардлыг нэмэгдүүлэн баталжээ.

2.2 Орон нутгийн төсвийн зарлагын бүтцэд урсгал зардал 71 хувь, хөрөнгийн зардал 27 хувь, цэвэр зээл 2 хувийг тус тус эзэлж байгаа нь төсвийн ихэнх хэсэг нь урсгал зардалд чиглэж, эдийн засгийн өсөлт, хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалтын чиглэлийн санхүүжилт харьцангуй бага байгааг илтгэж байгаа тул хөгжлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор хөрөнгийн зардлын эзлэх хувийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

2.2.2 Сүхбаатар аймгийн 2024 оны төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 72,862.7 сая төгрөг буюу 70 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №5 Төсвийн зарлагын гүйцэтгэл /сая төгрөг/

Үзүүлэлт Б	Өмнөх оны гүйцэтгэл 1	2024 он		Зөрүү 5=3-4
		Тодотгосон төсөв 3	Гүйцэтгэл 4	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,253.2	103,951.5	72,862.7	31,088.7
УРСГАЛ ЗАРДАЛ	41,509.6	59,993.0	52,384.3	7,608.7
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,872.7	54,853.2	48,512.1	6,341.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,145.4	17,806.3	16,749.3	1,056.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,368.8	2,226.8	2,040.0	186.8
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,277.2	9,437.1	8,858.5	578.6
Хангамж, бараа материалын зардал	874.7	1,006.1	942.6	63.4
Нормативт зардал	3.7	18.5	18.0	0.5
Эд хогшил, урсгал засварын зардал	1,376.7	1,421.1	1,376.6	44.5
Томилолт, зочны зардал	321.2	453.7	427.3	26.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,616.9	6,549.9	6,010.4	538.7
Бараа үйлчилгээний бусад зардал	13,887.8	15,116.0	11,387.4	3,728.6
ТАТААС	868.4	1,453.5	1,446.9	6.5
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	387.2	712.5	712.5	-

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	481.2	740.9	734.4	6.5
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	768.5	843.8	768.4	75.4
Бусад урсгал шилжүүлэг	768.5	842.8	768.4	75.4
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,631.5	41,238.3	19,978.1	21,260.2
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	1,112.1	2,720.2	500.3	2,219.8
Сум хөгжүүлэх сан	1,112.1	2,720.2	500.3	2,219.8
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	67,642.7	84,944.7	63,669.5	21,275.2
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	16,990.6	17,153.7	16,990.7	163.0
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	16,990.6	18,215.7	17,515.4	700.3
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,757.0	77,111.5	55,216.1	19,895.4
Орон нутгийн төсвөөс	42,757.0	77,111.5	55,216.1	19,895.4
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	7,895.1	10,624.2	10,162.6	461.6

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.2.3 Орон нутгийн 2024 оны төсвийн зарлага 72,862.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй бөгөөд үүнээс бараа, ажил үйлчилгээний зардал 48,512.1 сая, татаас 1,446.9 сая, урсгал шилжүүлэг 768.4 сая, хөрөнгийн зардал 19,978.1 сая, эргэж төлөгдөх зээл (ХХС, ЖДҮ-ийн сан) 500.3 сая төгрөгийг тус тус эзэлж байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлийн тайланг баталгаажуулах аудитаар дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасан “өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллах” шаардлагыг зөрчин, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн зарим газар төсвөөс 282.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т заасан төсвийн хөрөнгийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах шаардлагад нийцэхгүй байгаа бөгөөд энэ нь төсөвт дарамт үүсгэж, эдгээр байгууллагын санхүүгийн бие даасан байдал хангагдахгүй байгааг харуулж байна. Иймд тухайн байгууллагуудын үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшинг шалгуур үзүүлэлтээр үнэлж, үр ашиггүй, тогтвортой үйл ажиллагаа явуулах боломжгүй нэгжүүдэд хуулийн дагуу дүн шинжилгээ хийж, бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах шаардлагатай байна. Энэ хүрээнд “Бичигт хөгжил” ОНӨААТҮГ-ыг татан буулгаж, “Түмэнцог” ОНӨААТҮГ-ыг суманд шилжүүлэн ажиллуулах шийдвэрийг гаргасан нь зохистой зохицуулалт болсон байна.
- **Баруун-Урт сумын хоршоо хөгжүүлэх сан:** ЗДТГ-ын үйл ажиллагааны 7.5 сая төгрөгийн зардлыг хоршоо хөгжүүлэх сангаас санхүүжүүлсэн.
- **Сүхбаатар аймгийн ЗДТГ:** ЭЕШ-д өндөр оноо авсан сурагч, тэдгээрийг бэлтгэсэн багш нарт олгосон урамшуулалд 26.0 сая төгрөгийн ХХОАТ суутган тооцоогүй нь татварын хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдаагүйд тооцогдох бөгөөд энэ нь төсвийн хяналт, санхүүгийн тайлагналт, татварын орлогын бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна.

БҮЛЭГ 3. Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 413 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 46 хувьтай байгаа нь төсвийн орлогын тасралт, худалдан авах ажиллагааны хоцролт, зохион байгуулалт хангалтгүй зэргээс шалтгаалж, хөрөнгө оруулалтын үр нөлөөг бууруулсан байна..

3.1 Сүхбаатар аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийт 63,039.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 413 төсөл, арга хэмжээг 36,301.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр аймаг, сумдын ИТХ-аар баталжээ.

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Хүснэгт № 6 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээний гүйцэтгэл /сая төгрөг/

№	Сум	ТАХ-ий тоо	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих			
1	Асгат	12	1,059.4	765.8	417.0	(348.8)	54
2	Баяндэлгэр	23	1,633.3	1,118.3	324.7	(793.6)	29
3	Дарьганга	26	1,016.9	690.2	292.6	(397.6)	42
4	Мөнххаан	25	1,388.6	1,157.6	401.9	(755.7)	34
5	Наран	16	1,759.3	871.0	774.7	(96.3)	88
6	Онгон	15	1,489.5	1,169.9	186.3	(983.6)	16
7	Түвшинширээ	24	996.0	978.0	309.9	(668.1)	31
8	Түмэнцогт	29	832.0	832.0	420.4	(411.6)	50
9	Сүхбаатар	24	4,551.0	2,552.7	1,656.6	(896.1)	65
10	Уулбаян	15	827.3	577.9	577.9	-	100
11	Халзан	12	650.7	650.7	106.5	(544.2)	16
12	Эрдэнэцагаан	32	7,094.1	3,715.7	2,247.0	(1,468.7)	60
13	Баруун-Урт	61	5,257.0	5,007.2	1,977.9	(3,029.3)	40
	Сумдын дүн	314	28,555.1	20,087.0	9,693.4	(7,143.50)	48
	Аймгийн дүн	59	34,483.9	16,214.1	7,076.7	(9,137.4)	44
	НИЙТ	413	63,039.0	36,301.1	16,771.1	(19,531.0)	46

3.1.1 Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжихээр батлагдсан өмнөх оноос шилжиж буй 24, шинээр хэрэгжих 15 нийт 39 төсөл, арга хэмжээнд 24,783.3 сая төгрөгийн санхүүжилт төлөвлөснөөс, 7,076.7 сая төгрөгийн зарцуулалт хийгдэж, гүйцэтгэл 44 хувийн биелэлттэй байна. Санхүүжилтийн гүйцэтгэл бага байгаа нь төслийн техникийн болон зураг төслийн баримт бичиг бүрдээгүй, төсвийн орлого дутуу бүрдсэн, төлөвлөлт хангалтгүй байсан, худалдан авах ажиллагааны зарим төсөлд тендер шалгаруулалт зарлагдаагүй эсхүл удаашралтай явагдсан, мөн орон нутгийн байгууллагуудын хэрэгжилтийг хариуцах ажлын зохион байгуулалт, хяналт, хамтын ажиллагаа сул байсантай холбоотой байна.

Эдгээр нөхцөл нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт удаашрах, зарим ажил хугацаандаа эхлэхгүйгээс үүдэн тухайн жилийн хөрөнгө оруулалт бүрэн ашиглагдахгүй байх, иргэдийн саналаар эрэмбэлэгдсэн зорилтот ажлууд хэрэгжихгүй үлдэх, улмаар олон нийтэд чиглэсэн үйлчилгээ, дэд бүтцийн хүртээмж саатах, иргэдийн оролцоонд суурилсан төсвийн зарцуулалт, итгэлцэлд сөргөөр нөлөөлөх, санхүүгийн сахилга, төсвийн төлөвлөлтийн бодит байдалд эрсдэл учруулах зэрэг сөрөг үр дагавар үүсгэх нөхцөл бүрдүүлж байна.

3.1.2 Тухайн жилд хэрэгжих 20 төсөл, арга хэмжээний 4,009.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгоогүй байна. Эдгээр төсөл арга хэмжээ нь холбогдох баримт бичиг дутуугаас худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй, тендер зарласан боловч амжилтгүй болсон, бүрэн хэрэгжээгүй, техникийн тодорхойлолтод заасан шалгуур, нөхцөлд нийцээгүй, гэрээг дүгнэж, улсын комисс хүлээж аваагүйтэй холбоотой байна.

Сумдын ИТХ-аар ОНХС-ийн хөрөнгөөр нийт 314 төсөл, арга хэмжээнд 20,087.0 сая төгрөг зарцуулахаар баталсан байна. Сумдын хэмжээнд санхүүжилтийн гүйцэтгэл 48 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь малын орлогын татварын гүйцэтгэл 38 хувь буюу бүрэн төвлөрөөгүйгээс санхүүжүүлэх эх үүсвэргүй болсон, тендер зарлаагүй, тухайн арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл үүсээгүй гэх мэт хүчин зүйлүүд нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- **Дарьганга сум:** Тайлант онд 379.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 ТАХ нь зураг төсөвгүй, тендер зарласан боловч гүйцэтгэгч компани оролцоогүй, малын хөлийн татвар тэглэсэн зэрэг шалтгаанаар огт хэрэгжээгүй бөгөөд үүний улмаас төлөвлөсөн ажлууд хугацаандаа эхлээгүй, төсвийн зарцуулалт хойшилж, бодлогын хэрэгжилт саатах нөхцөл үүссэн байна.

- **Асгат сум:** Нэгдүгээр багт баригдах багийн төвийн барилгын зураг, төсөв боловсруулах гэрээний дагуу ажил бүрэн дуусаагүй, хүлээж аваагүй байхад төлбөрт 12.4 сая төгрөгийг бүрэн шилжүүлсэн.
- **Наран сум:** Наадмын талбайн засвар, тохижилтын ажлын зураг, төсөв боловсруулах гэрээний дагуу ажил бүрэн дуусаагүй, хүлээж аваагүй байхад төлбөрт 15.0 сая төгрөгийг бүрэн шилжүүлсэн.
- **Эрдэнэцагаан сум:** Гудамж талбайд гэрэлтүүлэг хийх ажилд 20.0 сая төгрөг шилжүүлсэн боловч ажил хийгдээгүй байна.
- **Түвшинширээ сум:** ОНХС-ийн хөрөнгөөр худалдан авсан 3100 боодол 31.7 сая төгрөгийн өвсийг данс бүртгэлд тусгалгүйгээр зарцуулсан.

Сумдын түвшинд төсөв, төлөвлөлт, хэрэгжилтийн уялдаа, санхүүгийн сахилга бат, хяналт хариуцлага хангалтгүй байгаагаас зарим төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд хэрэгжээгүй, зарцуулалтын үр ашиг алдагдсан, төрийн бодлогын хэрэгжилт саатах нөхцөл бүрдсэн байна.

Энэ нь төлөвлөлт, гүйцэтгэлийн уялдаа хангагдаагүй, зураг төсөв, нөхцөл боломжийг бодитой үнэлээгүй, худалдан авах ажиллагаа, гэрээний хэрэгжилт, санхүүгийн хяналт сул, орлого бүрдүүлэлтийн төлөвлөлт алдаатай байсны үр дүн юм. Үүний улмаас төсвийн зарцуулалт хойшлогдож, хөрөнгө оруулалтын үр өгөөж буурч, төрийн үйлчилгээний хүртээмж, бодлогын хэрэгжилт тасалдах сөрөг үр дагавар бий болсон байна

3.2 Их засварын чиглэлээр нийт 14 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс он дамжин хэрэгжсэн арга хэмжээ бүрэн дууссан бөгөөд шинээр эхлүүлсэн арга хэмжээний гүйцэтгэл 80 хувийн биелэлттэй байна.

3.2.1 Тайлант Тайлант онд их засварын зардлаар хэрэгжүүлэхээр 13 төсөл, арга хэмжээнд нийт 1,054.0 сая төгрөгийн хөрөнгө батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 9 төсөл, арга хэмжээнд 883.5 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, 83.8 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №7 Их засварын зардлаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гүйцэтгэл /сая төгрөг/

д/д	Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний нэр	хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих	Гүйцэтгэл хувь
1.1	Аймгийн засаг даргын тамгын газрын барилгын их засвар, шинэчлэлийн ажил	2022-2024	716.1	56.8	100
1.2	Сургуулийн гадна дулаалгын их засвар 2 сургууль	2023-2024	510.0	22.9	100
1.3	Спорт заалны дээврийн засвар /Түмэнцогт сум/	2023-2024	50.0	2.9	100
1.4	Сургуулийн засвар /Уулбаян сум/	2023-2024	112.0	6.5	100
1.5	Төрийн захиргааны 2-р байрны хурлын заалны засварын нэмэлт ажил	2022-2024	29.0	29.0	100
1.6	Соёлын төвийн барилгын их засварын ажлын санхүүжилт / Асгат сум/	2020-2022	201.7	10.0	100
1.7	Боловсрол өргөө нэгдсэн дотуур байрны дээврийн их засвар/ Баруун-Урт сум /	2022-2024	113.3	5.1	100
1.8	Бага сургуулийн дээврийн засварын ажлын барьцаа санхүүжилт /Мөнххаан сум/	2023-2024	146.0	6.8	100
ДҮН			1,878.1	140.1	100
2.1	Сургуулийн их засвар /Асгат сум/	2024	500.0	500.0	100
2.2	Өвсний үндэс төслийн аймгийн оролцоо	2024	928.0	0	-
2.3	Тоглоомын талбайн засвар 1 баг /Баруун-Урт/	2024	150.0	0	-
2.4	Сумын ЭМТөв засвар /Онгон сум/	2024	475.0	475.0	100
2.5	Соёлын төвийн дээврийн засвар /Түмэнцогт сум/	2024	46.0	46.0	100

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.6	Дулааны станцын 1 болон 2-р зуухны засвар шинэчлэлт	2024-2025	2,839.7	1,829.4	64
	ДҮН		4,788.7	2,982.4	60
	НИЙТ ДҮН		6,666.8	3,122.5	80

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын судалгаа, тайлан

3.2.2 Аймгийн их засварын хөрөнгөөр өмнөх оноос шилжиж ирсэн 8 төсөл, арга хэмжээг 140.1 сая, шинээр хэрэгжиж буй 6 төсөл, арга хэмжээг 3,122.5 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

3.2.3 Төсөл, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаад зураг төсөвгүй, тендер зарлагдаагүй, гүйцэтгэгч сонгогдоогүй, хөрөнгө оруулалтын ажлыг эхлүүлэх нөхцөл бүрдээгүй, төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлт бодитой бусаас шалтгаан нөлөөлсөн байна.

3.3 Орон нутгийн хөрөнгө оруулалт 80.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд 3 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгоогүй байна.

3.3.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шилжиж ирсэн 6, шинээр хэрэгжих 12 төсөл, арга хэмжээг 3,204.3 сая төгрөгөөр гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт № 8 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэл /сая төгрөг/

д/д	Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний нэр	хэрэгжих хугацаа	төсөвт өртөг	2024 онд санхүүжих	Гүйцэтгэл	Хувь
1	Шилжих хөрөнгө оруулалт					
1.1	Тусгай зориулалтын автомашинуудын автограш барих / Онцгой байдлын газар/	2021-2024	314.0	15.7	314.0	100
1.2	Мал эмнэлгийн лабораторийг биохимийн шинжилгээ хийх тоног төхөөрөмжөөр хангах	2023-2024	68.7	3.4	68.7	100
1.3	Багийн төвийн өргөтгөл, шинэчлэлт / Баяндэлгэр сум, Хонгор баг/	2023-2024	250.0	12.3	250.0	100
1.4	Сумдын ЗДТГ-т автомашин худалдан авах / 10 сум/	2023-2024	2,250.0	112.5	2,250.0	100
1.5	Цэцэрлэгийн гадна тоглоом авахад дэмжлэг /Уулбаян сум Цэцэрлэг/	2023-2024	20.0	20.0	20.0	100
1.6	Гэр дулаалга төсөл /Баруун-Урт сум 3-р баг/	2022-2024	62.9	62.9	62.9	100
	ДҮН		2,965.7	226.9	2,965.7	100
2	Шинэ хөрөнгө оруулалт					
2.1	Гэр хорооллын өрхүүдэд халаалт, дулаан, агаар сэлгэлтийн Чип багц нийлүүлэх/Баруун-Урт сум/	2024	2,600.0	1,300.0	1,300.0	100
2.2	Автоклав худалдан авах /МЭГазар/	2024	30.0	30.0	30.0	100
2.3	Тоног төхөөрөмж худалдан авах/Жаахан шарга ХЖТ/	2024	76.0	76.0	76.0	100
2.4	Газар чөлөөлөлт/Баруун-Урт сум/	2024	300.0	300.0	300.0	100
2.5	Бэлчээрийн менежментийг сайжруулах хүрээнд хадлан тэжээлийн нөөц газар байгуулах/Адапт төслийн оролцоо/	2024	378.1	113.4	113.4	100
2.6	Төрийн албан хаагчдын орон сууц барих /Наран сум/	2024	640.0	-	-	-
2.7	Төрийн байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх хүрээнд автомашин худалдан авах/АЗДТГ/	2024	80.0	80.0	80.0	100
2.8	Гэр хорооллын гудамж зам талбайг тэгшлэх, засварлах /Баруун-Урт сум/	2024	220.0	-	-	-
2.9	Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлэх	2024	450.0	144.8	144.8	32.2
2.10	Нутгийн залуучууд хөтөлбөр хэрэгжүүлэх	2024	150.0	10.0	10.0	6
2.11	2 суманд өвс тэжээлийн агуулах барих / адапт төслийн оролцоо/	2024	360.3	108.0	108.0	100

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.12	Гэр худалдаж авах	2024	270.0	-	-	-
	ДҮН		5,334.4	2,977.4	2,977.4	61.5
	НИЙТ ДҮН		8,300.1	3,204.3	5,943.1	80.7

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын судалгаа, тайлан

3.3.2 Тайлант онд нийт 18 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөгдсөнөөс 13 нь бүрэн хэрэгжиж, 2 арга хэмжээ 6-32 хувийн гүйцэтгэлтэй, 3 арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. Үл хэрэгжсэн болон гүйцэтгэл хангалтгүй байгаа арга хэмжээнүүд нь орон нутгийн төсвийн орлого тасарсантай холбоотойгоор санхүүжилтийг эрэмбэлэн олгосны үр дагавар юм.

Аудитын илрүүлэлт:

- Орон нутгийн төсвөөс болон хандив, дэмжлэг, төвлөрсөн эх үүсвэрээс нийлүүлэгдсэн өвс, тэжээл, хүнсний бүтээгдэхүүн, нүүрс зэрэг нийт дүнгээр хэд хэдэн эх сурвалжаас нийлүүлэгдсэн 2,234.2 сая төгрөгийн үнэ бүхий хангамжийг холбогдох төсвийн байгууллагууд санхүүгийн бүртгэлд тусгаж, зарцуулалтын тайлагнал, хяналтыг хангаж ажиллаагүй нь төсвийн сахилга бат, хөрөнгийн үр ашигтай ашиглалт, ил тод байдлыг хангахад сөргөөр нөлөөлсөн байна.

3.4 Авто замын сангаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ 80 хувийн гүйцэтгэлтэй боловч авто замын нөхөөсний ажлыг чанаргүй гүйцэтгэсэн байна.

3.3.3 Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар өмнөх оноос шилжиж ирсэн 6, шинээр хэрэгжүүлэх 4 нийт 2,532.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 10 төсөл, арга хэмжээг 1,107.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж баталсан.

Хүснэгт №9 Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ий гүйцэтгэл /сая төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжих хугацаа	төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн	Гүйцэтгэл	Хувь
1	Зэвсэгт хүчний 338 дугаар анги хүртлэх хатуу хучилттай автозам / Баруун-Урт сум, /	2022-2024	751.8	50.1	701.7	93
2	Баруун-Урт сумын төвийн хатуу хучилттай автозам, замын байгууламжийн хэсэгчилсэн засвар, нөхөөс /2-р тойрог/	2022-2024	180.0	72.8	-	-
3	Эко хорооллын автозамын ажил / Баруун-Урт сум, 7-р баг/	2023-2024	500.0	408.2	302.3	60
4	Аймгийн авто замын засвар нөхөөс	2023-2024	350.0	129.6	-	-
5	Баруун-Урт сумын 1-р баг 60 айл, Грийн таун, музей чиглэлийн автозам /630м+400м/	2022-2024	520.0	34.1	-	-
6	Том оврын автомашины хөдөлгөөн хязгаарлах тэмдэг тэмдэглэгээ	2023-2024	13.0	-	-	-
7	Авто замын хэсэгчилсэн засвар, арчлалт, нөхөөс ус зайлуулах хоолой барих(Баруун-Урт сум)	2024	192.0	171.0	171.0	89
	НИЙТ ДҮН		3,070.8	1,464.9	1,175.0	80

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын судалгаа, тайлан

3.3.4 Тайлант онд авто замын сангийн санхүүжилтийн гүйцэтгэл 1,175.0 сая төгрөг буюу 80 хувийн биелэлттэй байгаа боловч дараах ажлуудыг гүйцэтгэгчээр дахин хийлгэх шаардлагатай байна.

Аудитын илрүүлэлт:

- Баруун-Урт сумын төвийн хатуу хучилттай автозам, замын байгууламжийн хэсэгчилсэн засвар, нөхөөс /2-р тойрог/ ажлыг Ханан салхит ХХК нь шалгарч

гүйцэтгэсэн боловч улсын комисс хүлээн аваагүй гүйцэтгэгчээр дахин хийлгэх комиссын даалгавар гарсан байна.

- Аймгийн авто замын засвар нөхөөсний ажлыг Монгол зам групп ХХК гүйцэтгэсэн бөгөөд уг ажлыг улсын комисс хүлээн аваагүй дахин чанартай хийлгэхээр комиссын даалгавар гарсан байна.
- Авто замын хэсэгчилсэн засвар, арчлалт, нөхөөс хийх (Баруун-Урт сум) ажлыг 180.0 сая төгрөгөөр Талын зам ТӨХК гүйцэтгэж улсын комисс хүлээн авсан байна. Гэтэл Тэспетролиум чиглэлийн автозамын хэсэгт ус зайлуулах шугам байхгүйгээс хийсэн ажил чанарын баталгааны хугацаанаас өмнө эвдэрсэн, Номин супермаркетын урд талаас Залуус хотхон хүртэлх замын суурь солих шаардлага үүссэн байна. Дээрх замуудад ус зайлуулах хоолой хийх, замын суурийг бүхэлд нь шинэчлэх, нарийвчилсан шинжилгээ хийх шаардлагатай байна.



Авто замын засвар, нөхөөсний чанар хангалтгүй, техникийн дутуу судалгаа, ус зайлуулах шугам, суурийн баталгаа болон хяналт шалгалтын үйл явцын алдаа нь улсын комисс хүлээн аваагүй гүйцэтгэлд хүргэж, дахин чанартай хийх шаардлага үүсгэсэн байна.

БҮЛЭГ 4. Орон нутгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг төсвийн төсөлтэй уялдуулсан байна.

4.1 Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуульд заасан шалгуурт нийцүүлэн тайлагнасан байна.

4.1.1 Сүхбаатар аймгийн Засаг даргын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн тайлангаар 18 хөтөлбөр, арга хэмжээнд 72,862.7 сая төгрөгийг зарцуулж, гүйцэтгэл 70.0 хувьтай байна.

Хүснэгт№ 10 Төсвийн гүйцэтгэл /хөтөлбөрөөр/ (сая төгрөг)

Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
70105- ОН-ын өөрөө удирдах ёсны байгууллага	4,931.9	4,664.8	267.1	95
70106- ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	77,838.5	51,728.8	26,109.7	66
70202- Санхүү, төсвийн нэгдсэн удирдлага	614.8	606.4	8.4	99
70418-Худалдан авах ажиллагаа	348.3	293.1	55.2	84
70426- Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	425.9	330.4	95.5	78
70504- Доод шатны төсвөөс дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлого	651.2	651.2	0.0	
71101- Авто зам	1,464.9	613.9	851.0	42
71401- Хог хаягдал	3,795.1	3,401.6	393.5	90
71403- Ойжуулалт	108.7	108.7	0.0	100
71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	1,662.5	1,162.3	500.2	70
71602- Эмнэлгийн тусламж үйлчилгээ	1,663.9	1,606.8	57.1	97
71701- Биеийн тамир спорт	841.4	703.2	138.2	84
71702- Соёл урлаг	1,053.6	996.8	56.8	95
71801- Сургуулийн өмнөх боловсрол	1,836.2	1,689.3	146.9	92

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

71802- Ерөнхий боловсрол	3,925.9	3,748.4	177.5	95
71804- Мэргэжлийн боловсрол	256.2	256.2	0.0	100
71902- Нийгмийн халамж	132.9	132.9	0.0	100
72101- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	2,399.2	167.9	2,231.3	7
НИЙТ ДҮН	103,951.1	72,862.7	31,088.4	70

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс

4.1.2 Төсвийг хөтөлбөр арга хэмжээ, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, төсвийн захирагч бүрээр бэлтгэн батлуулж, гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд нийцүүлэн тайлагнасан байна.

4.1.3 Төсвийн төвлөрүүлэн захирагч нар хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийн хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, баталгаажуулах ажиллагаа зохиох түвшинд хийгдээгүй нь хөтөлбөрийн хэрэгжилтийн бодит үр дүн, үр нөлөөг төсвийн зарцуулалттай уялдуулан үнэлэх боломжийг хязгаарлаж, төсвийн төлөвлөлт, хариуцлагын тогтолцоонд сөргөөр нөлөөлсөн байна.

4.1.4 Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөтөлбөрийн биелэлт 7 хувьтай, хангалтгүй байгаа нь хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмыг шинэчлэн мөрдүүлсэнтэй холбоотойгоор шалгуур хангасан хуулийн этгээд материал ирүүлээгүйгээс үүдэж, хөтөлбөрийн хэрэгжилт удааширч, төсвийн төлөвлөсөн зорилтот дүн биелээгүй байна.

4.2 Аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд батлагдсан зарим арга хэмжээний санхүүжүүлэх эх үүсвэрийг төсвийн төсөлд бүрэн тусгаагүйгээс хэрэгжээгүй байна.

4.2.1 Сүхбаатар аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан 4 зорилт, 111 арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулж, гүйцэтгэлийг 82 хувьтай үнэлэгдсэн байна.

Хүснэгт № 11 Хөгжлийн төлөвлөгөөний биелэлт (сая төгрөг)

№	2023 оны хөгжлийн төлөвлөгөөний зорилт	Төлөвлөгөө	Биелэлт хувиар						Дундаж хувь	Зарцуулсан төсөв
			0	30	50	70	90	100		
1	Хүний хөгжлийн бодлого	32	2	-	1	5	5	19	85	8,762.2
2	Эдийн засгийн бодлого	51	3	6	2	7	1	22	77	25,206.1
3	Засаглал	13	2	-	-	2	9	83	83	606.9
4	Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого	15	3	1	-	1	1	9	72	1,847.9
	НИЙТ	111	10	7	3	13	1	59	79.2	36,423.1

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн Төрийн захиргаа, удирдлагын хэлтэс

4.2.2 Сүхбаатар аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 111 арга хэмжээнд 36,423.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

4.2.3 Төлөвлөсөн нийт 111 арга хэмжээний 78 нь 90-100 хувийн, 13 нь 70 орчим хувийн, 10 нь 30-50 хувийн хэрэгжилттэй байгаа нь зарим арга хэмжээний хэрэгжилтэд ахиц гарсныг харуулж буй хэдий ч 4 арга хэмжээг хэрэгжүүлэх төсөв батлагдаагүй, тендерийн шалгаруулалтад оролцогч шалгараагүй зэрэг шалтгаанаар үнэлэх боломжгүй, 6 арга хэмжээ огт хэрэгжээгүй байгаа нь төсөв, төлөвлөлт, тендерийн үйл явц, хэрэгжилтийн зохион байгуулалт хангалтгүй байсныг илтгэж, үр дүнд суурилсан үнэлгээ хийх, бодит хэрэгжилтийн түвшнийг тодорхойлох боломжийг хязгаарлаж, байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөнд сөргөөр нөлөөлсөн байна.

4.2.4 Тайлант хугацааны гүйцэтгэлийг 82 хувиар үнэлсэн боловч зарим арга хэмжээний биелэлтийг үндэслэлгүйгээр хэт өндөр үнэлж, бодит гүйцэтгэлийг үнэлэхэд ашиглах

шалгуур, баримт нотолгоо тодорхой бус байжээ. Үүний улмаас аудитаар тоон болон чанарын үзүүлэлтэд тулгуурлан гүйцэтгэлийг 79.2 хувьтай гэж үнэлэхээр байна. Төсөл, хөтөлбөрийн үнэлгээг бодитой хийхийн тулд тухайн арга хэмжээний үр дүнг баталгаажсан эх сурвалж, тоон мэдээлэл, баримт бичигт тулгуурлан үнэлж, үнэлгээний аргачлал, шалгуур үзүүлэлтийг урьдчилан тодорхой болгож, хэрэгжилтийн биелэлтийг ил тод тайлагнах шаардлагатай байна. Тухайлбал: /Хүснэгт 11/

- Цэцэрлэгийн барилгын хана цуурч, эвдэрсний улмаас үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон бөгөөд гүйцэтгэгч байгууллагаас хоёр удаагийн их засвар гүйцэтгэсэн ч цэцэрлэгийн ашиглалт сэргээгүй, үйл ажиллагаа явагдаагүй байхад уг арга хэмжээг 100 хувиар үнэлсэн нь гүйцэтгэлийг бодит үр дүнтэй уялдуулан үнэлээгүй, ашиглалтад үндэслээгүй дүгнэлт хийгдсэн байна.
- Зорилтод түвшин нь 100 хувь, хүрсэн түвшин 70 хувь байхад арга хэмжээг 90 хувиар үнэлсэн нь гүйцэтгэлийн бодит байдлыг хэт өндөр үнэлсэн, үнэлгээний зарчим, дотоод хяналтын механизмыг хангалтгүй хэрэгжүүлсэн нөхцөл байдал үүсгэжээ.
- Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 426.7 км төмөр зам, холбогдох дэд бүтцийн барилгын ажил эхлээгүй байхад 30 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн нь ажил эхлээгүй нөхцөлд гүйцэтгэл тооцсон, үр дүнгийн үнэлгээний зарчимд нийцэхгүй алдаатай дүгнэлт хийгдсэнийг илтгэж байна.
- 2024 онд уул уурхайн 16 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан боловч тэдгээрээс 12 нь гэрээгээ дүгнүүлж, 4 нь дүгнүүлээгүй байхад арга хэмжээг 100 хувиар үнэлсэн нь хэрэгжилтийн бодит түвшинд үндэслэлгүй, дүгнэлт гүйцэтгэлийн зарчим, хариуцлагын үнэлгээг гажуудуулсан байна.

Гүйцэтгэлийн бодит байдал хангагдаагүй, зарим арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй, ашиглалтад ороогүй, эсхүл эхлээгүй байхад өндөр хувьтайгаар үнэлсэн нь гүйцэтгэлийн үнэлгээг зорилтот түвшинд хүрсэн бодит үр дүнтэй уялдуулахгүйгээр үнэлгээний бодитой байдал, хариуцлагын тогтолцоонд сөрөг нөлөө үзүүлэх үнэлгээ хийгдэж байна.

4.2.5 Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар тогтоолоор 1353 иргэнд 105.07 га газар өмчлүүлэх саналыг баталж, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 9.1.2-т заасны дагуу Засгийн газарт хүргүүлсэн боловч 2024 оны 137 дугаар тогтоолоор 154 иргэнд 12.9 га газар өмчлүүлэх шийдвэр гарсан бөгөөд Баруун-Урт сумын 686 иргэнд газар өмчлүүлэх нөөц газрын төлөвлөгөө, тогтоолыг сум, аймгийн түвшинд батлуулан хүргүүлсэн ч батлагдаагүй нь орон нутгийн төлөвлөлт, хэрэгжилт, төвлөрсөн шийдвэр гаргалтын уялдаа холбоо сул байгааг харуулж, иргэдийн газрын өмчлөх эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд хүндрэл учруулсан байна.

БҮЛЭГ 5. Нэмэлт төсвийн эх үүсвэрийг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн, зарцуулжээ.

5.1 Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны нэмэлт төсөвт Засаг даргын нөөц хөрөнгөөс 1,163.7 сая, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 497.1 сая, дээд шатны төсвийн захирагчаас 717.8 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,649.8 сая нийт 4,028.4 сая төгрөгийн орлого бүрдүүлжээ.

5.2 Нэмэлт төсвөөр бүрдүүлсэн эх үүсвэрийг эдийн засгийн ангиллаар дараах зардлуудад 4,025.0 сая төгрөг зарцуулж, үлдэгдэл 29.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №12 Орон нутгийн нэгдсэн төсвийн нэмэлт төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)

Зардлын үзүүлэлт	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,054.1

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2024 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

УРСГАЛ ЗАРДАЛ	4,025.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,121.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	48.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18.5
Хангамж, бараа материалын зардал	233.5
Нормативт зардал	10.5
Эд хогшил, урсгал засварын зардал	65.2
Томилолт, зочны зардал	20.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	723.6
Бараа үйлчилгээний бусад зардал	1.996.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	903.3
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	467.7
Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	435.6
Төвлөрүүлэх шилжүүлэг	435.6

Эх сурвалж: Сүхбаатар аймгийн ЗД-ын 2024 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогод сумдын өвс тэжээлийг худалдан борлуулсны орлого, ухаалаг худгийн усны төлбөрийн орлогууд эзэлж байна. Нэмэлт төсвийн 87.0 хувийг бараа ажил үйлчилгээний зардалд, 13.0 хувийг урсгал шилжүүлэгт тус тус зарцуулжээ.

БҮЛЭГ 6. Санхүү, төсвийн үйл ажиллагаатай холбоотой ил тод мэдээлбэл зохих мэдээллийг ШДНЦХ-т байршуулаагүй, хугацаа хоцроож мэдээлсэн байна

6.1 Төсөв захирагч нар Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

6.2 Шилэн дансны нэгдсэн сайтад холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд байршуулаагүй, авлага, зээл, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр болон таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг мэдээлээгүй нийтлэг зөрчил илэрлээ. Үүнийг хүснэгтээр харуулбал:

<i>Хүснэгт №13 Зөрчлийн нэгтгэл /Тоон мэдээллээр/</i>			
Төсөв захирагч	Хуулийн заалт	Алдаа зөрчлийн төрөл	Нийт зөрчил
Аймгийн ЗД	ШДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4.5	5 сая төгрөгөөр дээш орлого, зарлагыг мэдээлээгүй	2
	ШДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4	Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	2
	ШДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4.8	ШДТХ-ийн 6.4.8-д заасан шийдвэрийг мэдээлээгүй	1
	ШДТХ-ийн 6 дугаар зүйлийн 6.4.4	ШДТХ-ийн 6.4.4-д заасан шийдвэрийг мэдээлээгүй	1
Онгон сумын ИТХ	ШДТХ-ийн 6.4.5, 6.4.8-д заасан мэдээллийг нэгдсэн цахим системд мэдээлээгүй	ШДТХ-ийн 6.4.5, 6.4.8-д заасан мэдээллийг нэгдсэн цахим системд мэдээлээгүй	1
НИЙТ			7

6.3 Жил бүр санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг холбогдох албан тушаалтанд танилцуулж зөрчлийг давтан гаргахгүй байх аудитын шийдвэрийг хүргүүлж

байгаа боловч хуулийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байна. Дээрх дурдсан зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр аудитын шийдвэрүүдийг гаргаж, баталгаажуулалт хийн СТА-ын тайланд дурдсан.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар:

Аудитын илрүүлэлт:

- **Сүхбаатар сумын ЗДТГ:** Сумын 100 жилийн ойн баяр наадмыг зохион байгуулж, ажилласан албан хаагчдад 11.9 сая төгрөгийн шагнал, урамшууллыг цалингийн зардлаас бодож үр дүнгийн урамшуулалтай давхардуулсан.
- Тээвэр шатахууны зардлын үлдэгдлийг төвлөрүүлэлгүй Сүхбаатар НИК салбар руу шилжүүлж 2.5 сая төгрөгийн шатахууны талоныг бараа материалын тайланд үлдэгдлээр илэрхийлсэн.
- Мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас Хатгин наадмыг зохион байгуулахад 11.8 сая төгрөг, зочид төлөөлөгчдийн хүлээн авалт, хоол, унаанд 11.5 сая төгрөг, сумын 100 жилийн ойн урлаг, соёлын тоглолтын төлбөрт 20.0 сая төгрөг нийт 43.3 сая төгрөгийг үндсэн чиг үүрэгт хамаарахгүй үйл ажиллагаанд зарцуулсан байна.
- **Түвшинширээ сумын ЗДТГ:** Бэлтгэн нийлүүлэгч нарт шилжүүлсэн ажил гүйлгээний дүнгээс хувийн дансанд төсөв захирагч нь 28.2 сая төгрөгийг шилжүүлэн, зориулалт бус зарцуулж, гүйцэтгэл гаргасан.
- Няравын хувийн дансаар 7 ажил гүйлгээний 15.3 сая төгрөгийг дамжуулан зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4-р зүйлийн 4.1.6, 4.1.9 дэх заалтыг зөрчсөн байна.
- **Наран сумын ЗДТГ:** Нүүрс тээвэрлэгдээгүй, худалдан авалт хийгдээгүй байхад тээврийн хөлсийг урьдчилан олгосон нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, үндэслэлгүй санхүүгийн үүрэг хүлээх нөхцөл бүрдүүлэн, авлага, өр төлбөрийн зохицуулалтгүй зардал үүсгэх эрсдэл бий болсон.
- "Бахархалт цэцэрлэгт хүрээлэн" төсөлд зориулан Засаг даргын нөөц хөрөнгөөс 4.0 сая төгрөгийг мэргэжлийн бус байгууллагад шилжүүлсэн бөгөөд зураг төсөв батлагдаагүй байхад үлдэгдэл 4.0 сая төгрөгийг шилжүүлэхээр авлагаар бүртгэн, төсвийн хөрөнгийг зориулалтын бус зарцуулсан.
- Урсгал засварын зардлаас 8.0 сая төгрөг, ЗДНС-аас 15.0 сая төгрөгийн хийгдээгүй ажлын урьдчилгаа олгосны улмаас авлага үүссэн байна.
- **Халзан сумын ИТХ:** Байгууллагад самбар хийлгэхээр 1.5 сая төгрөгийг Түвшин АС БЭТ ХХК руу шилжүүлсэн. Гэвч тус компани нь цайны газар ажиллуулж, хүнсний ногоо тариалах үйл ажиллагаа явуулдаг бөгөөд уг төсвийн хөрөнгөөр байгууллагад шаардлагатай үйлчилгээ хийгдээгүй байна.
- Байгууллагын бүртгэлд байхгүй хөрөнгө буюу компьютерт засвар үйлчилгээ хийлгэж, төсвөөс 1.6 мянган төгрөгийг шилжүүлж, батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалт хийгдээгүй байна.
- **Аймгийн ИТХ:** Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2023 оны 4 дүгээр тогтоолыг дагаж, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд суудалтай Ардчилсан намд 20.0 сая төгрөгийн суудлын мөнгө олгосон.

Эдгээр зөрчлүүд нь төсвийн хяналт, санхүүгийн ил тод байдал, хариуцлагын тогтолцоог сулруулж, үр ашиггүй зарцуулалтыг үүсгэн, санхүүгийн зохицуулалтын алдаа болон төрийн сангийн удирдлагын системд эрсдэл үүсгэсэн бөгөөд, үүнээс үүдэн төсвийн хөрөнгийг буруу чиглэлд зарцуулж, төрийн хэмнэлтийн бодлого зөрчигдөж, төсвийн гүйцэтгэлийн зарим

зарлагыг зохисгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй зардалд зарцуулж, санхүүгийн бүтцийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлж байна.

---оОо---

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

ДҮГНЭЛТ

- Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө тасарсан нь газрын дуудлага худалдаа зохион байгуулагдаагүй, татварын хуваарилалт үндэслэлгүй, ногдуулалт, хяналт сул зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой бөгөөд энэ нь төсвийн орлогын тогтвортой байдал, зарцуулалтын үр ашиг, санхүүгийн сахилга батад сөргөөр нөлөөлсөн байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх иргэдийн саналаар эрэмбэлэгдсэн төсөл, арга хэмжээнд тайлант хугацааны дундуур өөрчлөлт оруулсан нь Сангийн сайдын 86 дугаар тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтийг зөрчиж, иргэдийн оролцоо, төсвийн ил тод байдлыг бууруулж байна.
- Хөрөнгө оруулалтын 413 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч гүйцэтгэл 46 хувьтай байгаа нь зураг төсөвгүй, тендер зарлаагүй, хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй, худалдан авах ажиллагааны удаашрал зэрэг шалтгаантай бөгөөд энэ нь хөрөнгө оруулалтын үр ашиг, төрийн үйлчилгээний хүртээмжийг бууруулж байна.
- Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот байгууллагууд төсвөөс 282.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан нь “өөрийгөө санхүүжүүлэх зарчим”-ыг зөрчиж, төсвийн үр ашиг, зохистой зарцуулалтад сөргөөр нөлөөлсөн тул бүтэц, зохион байгуулалтад дүн шинжилгээ хийж, үр ашиггүй нэгжүүдийг цэгцлэх шаардлагатай байна.
- Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг хэмжих шалгуур үзүүлэлт бүрэн тодорхойлоогүй, зарим төсөл арга хэмжээнд үр дүнгийн нотолгоо бүрдээгүйгээс хөгжлийн зорилтот түвшин, бодит гүйцэтгэлийн хооронд зөрүүтэй үнэлгээ хийгдэж, бодлогын хэрэгжилтийн үр нөлөө бүдгэрч, төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн чанарт сөргөөр нөлөөлсөн байна.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгдээгүй, байгууллагууд цахим хуудаст мэдээлэл байршуулах ажлын зохион байгуулалт хангалтгүй зэргээс төрийн санхүү, төсвийн үйл ажиллагааны ил тод байдал бүрэн хангагдахгүй байна.
- Орон нутгийн төсвийн зарцуулалтад 151.3 сая төгрөгийн зориулалтын бус зарцуулалт, хийгдээгүй ажилд урьдчилгаа олголт, хувийн дансаар гүйлгээ хийх, шаардлага хангаагүй этгээдэд төсвийн хөрөнгө шилжүүлэх зэрэг зөрчлүүд илэрч, төсвийн сахилга бат, хариуцлага, ил тод байдлыг алдагдуулсан байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитаар өгсөн дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Сүхбаатар аймгийн Засаг дарга, Санхүү төрийн сангийн хэлтэс:

1. Төсвийн орлогын төлөвлөлтийг өмнөх оны гүйцэтгэл, эдийн засгийн бодит нөхцөл байдал, салбар хоорондын мэдээллийн уялдаанд үндэслэн боловсруулж, хэт өөдрөг, үндэслэлгүй төлөвлөлтөөс зайлсхийх;

2. Татвар ногдуулах, бүрдүүлэх, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, орлогын гүйцэтгэлийг хариуцлагатай, тогтмол хянах механизм бүрдүүлэх;
3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдэд иргэдийн саналыг үндэслэлтэйгээр тусгаж, батлагдсан дарааллыг үндэслэлгүйгээр өөрчлөхгүй байж, оролцооны зарчмыг хамгаалсан төлөвлөлт, хэрэгжилтийн хяналтыг сайжруулах.

Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэст:

4. Хөгжлийн бодлого, хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэлийг баталгаатай эх сурвалж, бодит тоон болон чанарын үзүүлэлтэд тулгуурлан үнэлэх, хэт ерөнхий, үндэслэлгүй хувь дүгнэлтээс зайлсхийж, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг тогтмолжуулах.

Зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор багтаан Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

Аудитын тайлан баталгаажуулсан тушаал:



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/44

Баруун-Урт сум

**Аудитын тайланг баталгаажуулах
тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сүхбаатар аймгийн Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газар, аймгийн Засаг дарга, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (Т.Цэрэгбаяр)-т хүргүүлж ажиллахыг ахлах аудитор (Ө.Золзаяа)-д үүрэг болгосугай.

3. Аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг биелүүлж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоног, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор тус тус Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (М.Идэрбат), Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Ариунжаргал), Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (Т.Цэрэгбаяр) нарт хариуцуулсугай.

4. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Ө.Золзаяа)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг аудитын менежер (М.Нарантуяа)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

D:\Бичиг хэрэг\2025\Тушаал\А тушаал 2025.docx

2225010165